

ГЭМТ ХЭРГИЙН ХОР УРШИГ БА ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ДООД ХЭМЖЭЭНИЙ ХАРИЛЦАН ХАМААРЛЫН АСУУДАЛ

CRIME IMPACTS AND CORRELATION MINIMUM WAGE



Д.НАСАНБАТ

Монголын үндэсний их сургуулийн Хууль зүйн сургуулийн ахлах багш,
Хууль сахиулахын их сургуулийн докторант

NASANBAT D.

Senior teacher of Law School, Mongolian National University,
Doctoral candidate at the Law Enforcement University

Товч агуулга: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэсэн ойлголт бол Хөдөлмөрийн эрх зүйн харилцааг зохицуулахаар тооцоолж гаргасан хэмжүүр юм. Харин Эрүүгийн эрх зүйд материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэргийн объектив талын үндсэн шинж хохиролын хэмжээг тодорхойлж улмаар гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоох, гэмт хэрэг, зөрчлийг ялгах зааг болох нь эргэлзээтэй юм. Хор уршиг нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлоос өргөн хүрээтэй ойлголт бөгөөд гэмт хэргийн улмаас учирсан Эрүүгийн заасан бүх үр дагаврыг хамруулдаг бол хохирол нь хэргийн улмаас бусдын өмчлөх эрх, өмчлөгчийн эрх ашиг сонирхолд учирсан мөнгөн илэрхийллээр илэрч буй хор уршиг тул Эрүүгийн хуульд эрх зүйд хохирол талаас бус гэмт хэргийн хор уршиг нийгмийн аюул талаас нь тогтоох нь зүйтэй юм.

Abstract: The concept of minimum wage labor is a calculated measure to regulate legal relations. However, the nature of the material elements of criminal law offenses objective way to determine the amount of damages and determine the composition of the crime, crime, they are unlikely to be distinctive boundary violations. The consequences of the damage caused by extensive understanding of the crime caused by the crime and referred to the Criminal Code includes all the consequences because of a loss of property rights of others, the interests of rights owners of money caused damage because of possible damage to the Criminal law from crime consequences of the case should be set in terms of social harms caused.

Түлхүүр үгс: Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн хууль, Ерөнхий анги ба Тусгай анги, Гэмт хэргийн хор уршиг, Хохирол, Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив шинж, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр цалин хөлсний гурван талт хороо, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ.

Key words: Criminal law, Criminal code, General Parts, Special Parts, Crime damage, Damage, Objective nature of a crime, Labor Law, Labor and social consent National Committee, Labor minimum wage.

НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН ХОР УРШИГ, ХОХИРОЛ

Гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээг тодорхойлох гол шинж нь гэмт хэргийн хор уршиг юм. Аливаа гэмт хэрэг нь нийгмийн сөрөг үзэгдэл, хүний нийгэмд аюултай гэмт зан үйл болохын хувьд Эрүүгийн хуулиар

хамгаалсан нийгмийн эрх, ашиг сонирхолд халдан түүнд нийгэмд аюултай хор уршиг учруулах нөхцлийг бий болгодог ба тэрхүү учруулсан буюу учруулж болох байсан хор уршгаас гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ шалтгаална. Хор уршиггүй гэмт хэрэг гэж байхгүй бөгөөд түүний улмаас



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УНДГАДСАН
УНДГАДСАН
УНДГАДСАН

шууд ба шууд бусаар хор уршиг учрах бөгөөд гагцхүү тэр хор уршиг нь тухайн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж үзэх, Эрүүгийн хуульд заасан тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнд хэрхэн нөлөөлөх, амьдралд гарсан гэмт хэргийг зүйлчлэх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, оногдуулах ялын төрөл, хэмжээнд хэрхэн нөлөөлөх эсэх нь хор уршгийн Эрүүгийн эрх зүйн мөн чанарыг тодорхойлно.

Гэмт хэргийн хор уршигт нийгэмд аюултай, Эрүүгийн хууль зөрчсөн, гэм буруутай үйл явдлын үр дүнд Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаа болон гадаад ертөнцөд гарсан Эрүүгийн хуульд заасан өөрчлөлтийг хамруулна.¹ Гэмт хор уршиг гэдэг бол гэмт үйлдэл\эс үйлдэхүй\ хийх замаар халдлагын объект болох ЭХ-иар хамгаалагдсан эрх ашиг, харилцаанд учруулсан \гамшигт\ үр дагавар, өөрчлөлт юм². Энэ хоёр ойлголтыг адилтгаж болохгүй бөгөөд өөр, өөр утга санааг илэрхийлж, гэмт хэргийн эцэст бий болсон өөрчлөлт, үр дагавар бүхэн гэмт хэргийн хор уршиг болохгүй. Учир нь Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт хэргийн эцэст бий болсон үр дагавар нь дараах 2 шинжийг агуулсан тохиолдолд түүнийг гэмт хэргийн хор уршиг гэж үзэх бөгөөд энэ нь шинжээрээ гэмт хэргийн эцэст бий болох бусад үр дагавар болон бусад эрх зүйн зөрчлөөс дараах хоёр үндсэн зүйлээр ялгагдана. Үүнд :

а/ Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн улмаас учирсан байх;

б/ Эрүүгийн хуулийн Тусгай ангийн хэм хэмжээний диспозицид тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болон заагдсан байх. Энэ шинж нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн хэм хэмжээний диспозицид заасан, гэм буруутай этгээдийн нийгэмд аюултай, гэмт үйл ажиллагааны улмаас

¹ С.Жанцан. "Монгол улсын Эрүүгийн эрх зүй". УБ., 2011. 84 дэх тал.

² Ж.Болдбаатар, З.Төрмандах. Эрүүгийн эрх зүй. УБ., 2008. 30 дахь тал

зөрчигдсөн объект болох нийгмийн харилцаанд бий болсон үр дагавар, гарсан өөрчлөлт, төгсгөл юм. Материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэргийн хувьд гэмт хэргийн хор уршиг нь тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын заавал байх үндсэн шинж болж уг хэргийг Эрүүгийн хуулийн Тусгай ангийн тохирох зүйл, хэсгээр зүйлчлэхэд нөлөөлнө. Гэмт хэргийн хор уршгийн ойлголтыг одоогийн Эрүүгийн хуулийн Ерөнхий ангид хуульчлаагүй боловч, гэмт хэргийн хор уршгийн талаар заасан хэм хэмжээ цөөнгүй бий. Тухайлбал: Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 29, 55, 56, 61, 62, 70, 71, 74-р зүйл, заалтуудыг нэрлэж болно. Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 29-р зүйлд, Хохирлын хэмжээг тодорхойлохдоо:

Учирсан хохирлын хэмжээ	Гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж буй нэг сарын ХХДХ-г дараахь байдлаар өсгөсөнтэй тэнцэх хэмжээний мөнгөн төгрөг	192.000 төгрөг
Бага бус	1-50 дахин	192.000 - 960.000
Үлэмж	51-125 дахин	9.792.000 - 24.000.000
Их	126-200 дахин	24.192.000 - 38.400.000
Онц их	200-аас дээш дахин	38.400.000-аас дээш

Ингэж заасан ч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан бол эрүүгийн хариуцлага ялыг хөнгөрүүлэх нөхцөл байдал болгох, ял тэнсэх, хорих газраас хугацааны өмнө тэнсэн суллах болон эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх үндэслэл болгон заасан юм. Харин Эрүүгийн хуульд тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнийг заахдаа хор уршиг, түүний шинжийг хэрэг тус бүр дээр харилцан адилгүй байдлаар зааж өгсөн байдаг. Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнд хор уршигийг дараахь

байдлаар хуульчилж заасан байдаг. Үүнд:

Нэгд. Гэмт хэргийн улмаас учрах хор уршгийн шинж хэлбэр, төрлийг шууд хуульчилсан байна:

а/ Тодорхой нэг гэмт хэргийн улмаас учрах нэг хор уршгийг шууд заасан. Жишээ нь: Эрүүгийн хуулийн 263.1-д "... Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас аж ахуйн нэгж байгууллага, иргэнд үлэмж хэмжээний хор уршиг учруулсан бол ..." гэж хохирлын хэмжээг шууд хуульчилсан юм. Мөн ЭХ-ийн 99-р зүйлд: Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл учруулсан бол гэж хүний бие махбодид учруулсан хөнгөн гэмтлийг шууд зааж өгсөн байна.

б/ Тодорхой нэг гэмт хэрэг дээр учирч болох хэд хэдэн хор уршгийг хэд хэдэн шинж, хэлбэр, төрлийг хуульчилжээ. Харин Эрүүгийн хуулийн 96-р зүйлд "... Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан, өөрөөр хэлбэл амь биед нь аюултай гэмтэл учруулсан буюу хараа, сонсголгүй болгосон, эрхтнээс хагацуулсан, ажиллагаагүй болгосон, нүүрийг эвдэж дүрсийг алдагдуулсан, хүүхэд дутуу гаргуулсан, сэтгэцийн өвчтэй болгосон түүнчлэн хөдөлмөрийн чадварыг бүрмөсөн алдагдуулсан бол ..." гэж хүнд гэмтлийн хэд хэдэн шинж, хэлбэрийг зааж өгчээ. Түүнчлэн Эрүүгийн хуулийн 213-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Ой хээрийн түймэр тавих" гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд "... Ой хээрийн түймэр санаатай тавьсны улмаас ой бэлчээрийг устгасан, хүний амь нас хохирсон бусад хүнд хор уршиг учирсан, их хэмжээний хохирол учирсан бол ..." гэж энэ хэргийн улмаас учрах 4 өөр хор уршгийг заасан байна.

Хоёрт. Зарим хэргийн хор уршгийг шууд бусаар уг хэргийн улмаас учрах хор уршгийн нийтлэг шинжийг зааж өгсөн байдаг. Жишээ нь: Эрүүгийн хуулийн 109.3-д "... Хүнийг хууль бусаар хорьсны улмаас хүнд хор уршиг учирсан

бол..." гэж хор уршгийн шинжийг заасан энэ хэсэгт заасан хүнд хор уршигт ямар хор уршгийг ойлгох, ямар хор уршиг хамаарах талаар зааж өгөөгүй бөгөөд энэ тохиолдолд хор уршгийг тогтоох замаар тодорхойлно. Эрүүгийн хуулийн Тусгай ангийн тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнд заасан ийм хор уршгийг Эрүүгийн эрх зүйд үнэлж тогтоох /хэрэглэх/ хор уршиг гэж нэрлэдэг. Үнэлж тогтоох /хэрэглэх/ хор уршгийг хуульчлахдаа онц хүнд, хүнд хор уршиг, ноцтой хор уршиг, ноцтой үр дагавар, бусад хүнд хор уршиг, өөр бусад хор уршиг, өөр бусад хүнд хор уршиг гэх мэтээр заасан байдаг. Үнэлж тогтоох /хэрэглэх/ хор уршиг бүхий гэмт хэргийг зүйлчилэхэд практикт багагүй хүндрэл учирдаг. Учир нь хор уршгийн агуулга, нийтлэг шинжийг заасан байдаг нь түүнийг амьдралд гарсан тодорхой хэрэг /үйл явдал/-т хор уршгийн шинжийг тогтооход хүндрэл гарах, хуулийг хэрэглэж буй субъектууд хор уршгийн шинжийг тогтоох нь ийнхүү тусгасан логик санааг сайн олж илрүүлэх, түүний шинжийг амьдралд үйлдэгдсэн тодорхой хэрэгт тал бүрээс бүрэн дүүрэн бодитой тогтоох, зөв дүгнэлт хийхийг практик байгууллагын ажилтнаас шаарддаг. Үнэлж тогтоох /хэрэглэх/ хор уршиг бүхий гэмт хэргийг зүйлчлэхдээ практик байгууллагын ажилтнууд уг хэм хэмжээг тайлбарласан албан ёсны /УДШ-ийн тогтоол/ болон эрдэм шинжилгээний тайлбарыг удирдлага болгон түүнд тулгуурлан үнэлж хэрэглэх хор уршгийн агуулгыг зөв нээн илрүүлж, ийнхүү санааг амьдралд гарсан хэрэг дээр хэргийн нөхцөл байдал, хэрэг дээр учирсан бодит хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ зэргийг харгалзан дотоод итгэлээр Шүүн таслах ажиллагааны практик, ажлын дадлага туршлагад тулгуурлах нь зүйтэй. Үнэлж тогтоох хор уршиг бүхий гэмт хэргийг зөв зүйлчлэхэд УДШ-ийн тайлбар чухал үүрэгтэй бөгөөд түүнийг зөв удирдлага болгон



Хууль сахиулахуй

хэрэглэх нь гэмт хэргийг зөв зүйлчлэх нөхцөл болдог. Жишээ нь: Эрүүгийн хуулийн 126-р зүйлийн 3 дахь хэсэгт онц хүндрүүлэх бүрэлдхүүнтэй хүчиндэх хэргийг заахдаа "... уг хэргийн улмаас бусад хүнд хор уршиг учирсан ..." гэж хуульчилсан байдаг. Хүчиндэх гэмт хэргийн улмаас бусад хүнд хор уршиг учирсан гэдгийг УДШ-ийн 1989 оны 10-р сарын 13-ны 28-р тогтоолын 17-д "... энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүнд гэмтлийн улмаас хохирогч байнгын тахир дутуу буюу сэтгэл мэдрэлийн эдгэршгүй өвчтэй болсон, амиа хорлосон, хүүхэд дутуу төрүүлсэн, үр хөндүүлэхэд хүргэсэн байхыг ойлгоно..." гэж тайлбарласан байна.

Гуравт. Зарим гэмт хэргийн улмаас хор уршиг учирсан байхааар шууд зааж өгөөгүй боловч тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинж болох гэмт үйлдэл, эс үйлдэхүйн шинжийг тодорхойлох замаар энэ гэмт хэргийн улмаас хор учирсан байх, энэ хэрэг нь материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг болох нь харагдаж байна. Жишээ нь: Эрүүгийн хуулийн 153-р зүйлийн 1 дэх хэсэгт "...Бусдын эд хөрөнгийг санаатай устгасан буюу гэмтээсэн бол ..." гэж заасан ба энэ гэмт хэргийн объектив талын үйлдлийн шинжээс уг хэргийн улмаас бусдад эд материалын хор уршиг учирсан /гэхдээ хохирлын хэмжээг зааж өгөөгүй, материалын бага бус, үлэмж, их, онц, их хэмжээний хохирол учирсан байж болно. Мөн 151, 152, 181-р зүйлүүдийг нэрлэж болно.

Гэмт хэргийн хор уршгийн ангилал, төрөл: Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектын хүрээнээс хамаарч төрөл, хэлбэр нь олон янз байдаг ба түүнээс уламжлан дээрх харилцаанд учирсан хор уршиг нь ч мөн олон янз бөгөөд Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд шинж чанараас хамаарч: Материаллаг хор уршиг, Материаллаг бус хор уршиг³ хэмээн 2 шинжээр ангилсан.

Материаллаг хор уршиг гэдэг нь хүний амь бие, эрүүл мэнд, өмчлөх эрх зэрэг нийгмийн харилцаанд учирсан, илрэх гадаад хэлбэр бүхий бодит материаллаг шинжтэй хор уршигийг хэлнэ. Материаллаг хор уршиг нь ямагт түүнийг үнэлэх, тогтоох, хэмжиж болох тийм хор уршиг байдаг. Материаллаг хор уршиг нь амин хувийн /бие махбодийн/, эд хөрөнгийн хор уршиг гэж 2 төрөлд ангилна. Эд хөрөнгийн хор уршиг гэдэг нь гэмт үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдын өмчлөх эрхэнд учирсан хор уршигийг хэлэх ба эд хөрөнгийн хор уршиг нь ихэвчлэн бусдын өмчлөх эрхэнд учирсан хохирлоор тодорхойлогдоно. Хохирол нь бусдын өмчлөх эрх болон ЭХ-иар хамгаалагдсан, бусдын ашиг сонирхолд гэмт этгээдийн үйлдлийн улмаас учирсан мөнгөн илэрхийллээр илэрхийлэгдэх ихэвчлэн материаллаг шинж чанартай хор уршиг юм.

1998 онд батлагдсан "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ тогтоох тухай" МУ-ын хуулийн 3-р зүйлийн 1-д "... Тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардагдах энгийн ажил гүйцэтгэсэн ажилтанд олговол зохих ажлын хөлсний хамгийн бага хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэнэ..." гэж заасан бөгөөд Засгийн газар, ажил олгогч эздийн холбоо болон Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын саналыг харгалзан жилд нэгээс доошгүй удаа шинэчлэн тогтоодог.

Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн шинжтэй хор уршигийг /хохирлыг/ түүний шинжээр нь: а/ бусдын өмчлөх эрхэнд шууд учирсан хохирол, б/ бусдын эд хөрөнгөнд алдагдсан ашиг орлогын шинж чанартай учирсан хохирол гэж ангилна.

Гэмт хор уршгийн хууль цаазны учир холбогдол нь дараахь байдлаар илэрхийлнэ. Үүнд:

-Аливаа гэмт үйлдэл, эс үйлдэх нь гэмт хэрэг мөн эсэхийг шийдвэрлэхэд учирсан хохирол, түүний хэмжээ нь гол

³ С.Жанцан. "Монгол улсын Эрүүгийн эрх зүй". УБ., 2011. 84 дэх тал

үндэслэл, шалгуур болно.

-Зарим төрлийн Гэмт хэргийн бүрэлдэхүүний заавал байх шинжийн хувьд нийгэмт аюултай хор уршиг нь гэмт хэргийг зүйлчлэхэд чухал үүрэгтэй.

-Учирсан хохирол нь гэмт хэрэг болон эрх зүйн зөрчлийг хооронд нь ялгах шинж болно

-Гэмт хэргийн бүрэлдэхүүний заавал байх шинжээр хор уршигийг заагаагүй тохиолд хүндрүүлэх нөхцөл байдал гэж үзэх зэрэг хамаарна⁴.

Хор уршиг нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлоос өргөн хүрээтэй ойлголт бөгөөд гэмт хэргээс учирсан Эрүүгийн хуульд заасан бүх үр дагаврыг хамааруулдаг бол, хохирол нь гэмт хэргийн улмаас бусдын өмчлөх эрх, эд хөрөнгийн ашиг сонирхолд учирсан мөнгөн илэрхийллээр илэрч буй хор уршиг байдаг.

Хоёр. МУ-д мөрдөгдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түүний эрх зүйн зохицуулалтаас. Хөдөлмөрийн хөлсний зохицуулалтанд байх асуудал бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ мөн. Энэ нь эдийн засгийн болон хууль зүйн агуулга бүхий ухагдахуун юм. Үүнийг хууль болон судлаачид янз бүрээр тодорхойлжээ. Тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж байгаа ажилтан болон ажиллагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс тогтоосон цагийн үндсэн цалин /хөлс/-ийн нийтээр дагаж мөрдвөл зохих хамгийн доод хязгаарыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэнэ.⁵

ОХУ-ын Хөдөлмөрийн хуулинд «Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ»-гэдэг нь хөдөлмөрийн хэвийн нөхцөлд, мэргэжил үл хамаарах энгийн ажлыг гүйцэтгэхдээ ажлын цагийн

⁴ Ж.Болдбаатар, З.Төрмандах. Эрүүгийн эрх зүй. УБ., 2008. 30 дахь тал

⁵ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай Монгол улсын хууль. 2010

нормд бүрэн ажилласан ажилтны гүйцэтгэсэн ажилд төлөх ОХУ-ын хуулиар тогтоогдсон сарын хөдөлмөрийн хөлсний хэмжээ»⁶ гэж тодорхойлжээ.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний тухай ойлголтын салшгүй хэсэг бөгөөд энэ нь хуулиар тогтоосон хөдөлмөрийг ханган биелүүлсэн ажилтанд хөлс олговол зохих хуулиар тогтоосон хамгийн бага хэмжээ, зааг мөн⁷.

Төр төвлөрүүлэн зохицуулах механизмар дамжуулан хөдөлмөрлөгчдийн хөдөлмөрийн хөлсөнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, түүний бүтэц, бүрэлдэхүүндийг тодорхойлох, ажиллах хүчний хөлсний тодорхой хэлбэрүүдийг нэвтрүүлэх, хөдөлмөрийн хөлсний индекс болон түүний хэт өсөлтийг бууруулах зорилготой арга хэмжээг хэрэгжүүлэх замаар нөлөөлнө⁸.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь үйлдвэрийн хэвийн нөхцөлд, энгийн, мэргэжил үл шаардах ажилд болон ажлын цагийн нормд тогтоосон буюу ажил гүйцэтгэх үүргээ биелүүлсэн ажилтанд заавал журамлан олгох хөдөлмөрийн хөлсний сарын хамгийн доод хэмжээг улсын хуулиар баталгаажуулах шаардлагыг өөртөө агуулж байдаг⁹.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь олон төрлийн үүрэгтэй, Энэ нь ажилтны амьдралын наад захын хэрэгцээг хангах хэмжээ болон түүнд ажил олгогчийн хөлс төлөх үүрэг хариуцлагыг хуулиар баталгаажуулна.

МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн 48-р зүйлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хуулиар тогтооно хэмээн заасан. Ийнхүү төрөөс тогтооноор хөдөлмөрийн хэвийн харилцааг тогтоох улмаар ажилтны амьдралын тодорхой түвшинг баталгаажуулах ач

⁶ Трудовой кодекс. 2002. Статья 129.

⁷Л.Баасан. Монгол Улсын Хөдөлмөрийн эрх зүй. УБ., 2010. 257 дахь тал.

⁸⁵ Кисилев М.Я. Сравнительное и международное трудовое право. М., 1999. Стр. 188.

⁹ Куреннов А.М. Трудовое право России. М., 2004. Стр. 142

холбогдолтой. Ажил олгогч нь ажилчдын хөдөлмөрийн хөлс хуулиар тогтоогдсон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш хэмжээтэй байхаар хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн буюу хамтын гэрээгээр тогтоодог. Хөдөлмөрийн харилцаанд оролцогсод хөдөлмөрийн хөлсний хуулиар тогтоосон доод хэмжээнээс бага хөлс олгох эрхгүй. Энэ нь ажилтанд олгох хөлсний доод хэмжээ буюу баталгааг илэрхийлнэ.

Хуулиар тогтоосон жишиг хөлсний хэмжээг харгалзан:

1. Улсад ямар нэгэн байдлаар хөдөлмөр эрхэлж буй ажилтнуудыг хөдөлмөрийн хөлс цалинг тогтоох (Иргэний эрх зүйн гэрээгээр ажиллагсад, бусад хэлбэрээр хөдөлмөр эрхлэгсэд)

2. Зарим төрлийн гэмт хэрэгт торгох ял оногдуулах (Эрүүгийн хуулийн 47-р зүйлд зааснаар торгох ялын хэмжээ нь гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжинд заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно)

3. Өндөр насны бүрэн тэтгэврийн доод хэмжээг тодорхойлох (Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хуулийн 5-р зүйлд зааснаар өндөр насны бүрэн тэтгэврийн доод хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75%-иас багагүй байна)

4. Эрүүгийн хэргийн хохирлын хэмжээг тооцох (Эрүүгийн хуулийн 29-р зүйлд хохирлын хэмжээг тодорхойлсон), эрүүгийн хэрэг үүсгэх хохирлын доод хэмжээг тогтоодог.

1991 оны Хөдөлмөрийн тухай МУ-ын хуулинд анх удаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн газрас тогтоож байхаар хуульчилж өгсөн бөгөөд Засгийн газрын 1991 оны 199-р тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг «цагт 2 төгрөг 87 мөнгө», хөдөлмөрийн нэмэгдэл хөлсний

доод хэмжээг «цагт 30 мөнгө» байхаар анх тогтоосон.

Түүнчлэн УИХ “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай» хуулийг 1998 онд батлан гаргасан энэхүү хуулинд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн газар тогтоож байхыг хэвээр нь үлдээн, түүнийг улс орны эдийн засгийн өсөлт, бүтээмжийн түвшин, ажил эрхлэлтийн байдал, хүн амын амьжиргааны өртөг, тэдний бодит орлогын өөрчлөлт, нийгмийн даатгал, халамжийн шугамаар олгож буй тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, улсын хэмжээний цалин хөлсний түвшин зэргийг харгалзан жилд нэгээс доошгүйгээр тогтоож байхыг тухайн хуулинд тусгасан. Ийнхүү хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг жилд өөрчлөн тогтоож байх доод хугацааг тусгасан нь шилжилтийн улс орны эдийн засгийн өөрчлөлтийн үед зайлшгүй шаардлагатай юм.

2010 онд Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ тухай Монгол Улсын хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, хэд хэдэн шинэ заалтууд тусгагдсан. Үүнд:

-2008 онд Нийгмийн даатгалын тухай МУ-ын хуульд өөрчлөлт¹⁰ оруулсантай уялдуулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хэрэглэх хүрээг тодорхой тусгасан, Тухайлбал: Мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж байгаа ажилтанг хамруулсан.

Тодорхой боловсрол, тусгай мэргэжил, ур чадвар шаардах ажилд хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон эдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж байгаа ажилтны ажлын хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоохыг хориглосон. Энэ тохиолдолд ажилтны мэдлэг,

¹⁰ Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр ажиллагсдыг нийгмийн даатгалд хамруулахаар тусгасан. Мөн 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлтөөр дээрх тохиолдолд “ажилтныг албан журмаар даатгуулна” гэж оруулсан.



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УНДГАДСАН
УНДГАДСАН

мэргэжил, ур чадвар, ажлын үр дүнг зөв үнэлэн, тэдэнд олгох хөлсийг байгууллагын хамтын болон хөдөлмөрийн гэрээгээр харилцан тохиролцсон, төрийн албан хаагчдын цалинг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон цалингийн сүлжээг үндэслэн олгоно. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд нэмэгдэл болон нэмэгдэл хөлс, шагналт болон бусад урамшууллын хөлс, бусад нөхөн олговрыг оруулахгүй.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг засгийн газар, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл болох Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо тогтоох бөгөөд үүнтэй холбоотой түүний хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуульчилж өгсөн. Энэ мэтээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг засгийн газар, ажил олгогч эздийн байгууллага, үйлдвэрчний эвлэлүүдийн төлөөлөл зөвшилцөн шийдвэрлэх болов.

МУ-д ажил олгогч эздийг Монголын ажил олгогч эздийн холбоо, ажилтны эрх ашгийг МҮЭ-үүдийн холбоо төлөөлж, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн үндэсний гурван талт хороог бүрдүүлдэг. Өмнө нь Засгийн газар нөгөө 2 талын саналыг харгалзан дангаараа шийдвэр гаргадаг байв. Ийнхүү Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3-н талт үндэсний хороо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох болсон нь хөдөлмөрийн харилцаанд ардчиллыг ихээхэн гүнзгийрүүлсэн, нөгөө талаас 3-н талын нийгмийн хариуцлагыг адил тэгш түвшинд тавьж нэмэгдүүлсэн, талуудын чадавхийг дээшлүүлэхийг шаардсан хууль эрх зүйн цоо шинэ зохицуулалт болсон. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтооход гурван тал эрх тэгш, нээлттэйгээр оролцож, уг хуульд заасан зарчмыг баримтлан, зөвшилцөх замаар талууд санал нэгдсэн хувилбар дээр эцэслэн тохиролцох илүү ардчилсан аргад шилжиж байгаагаараа онцлог юм. Иймд цаг хугацаа шаардсан энэхүү ажлын үр дүнд гурван тал үндэсний эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, ажиллах хүчний эрх ашигт илүү ойр шийдвэрийг гаргах боломжтой болж байна.

2013 онд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг **192000** төгрөг буюу цагт **1142** төгрөг 85 мөнгөөр тогтоож одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд 2016 онд 240000 төгрөг буюу цагт **1428** төгрөг 60 мөнгө байхаар шинэчлэн тогтоож, 2017 оны 1-р сарын 1-нээс эхлэн мөрдөх юм.

Манай улсад 1991 оноос хойш хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг доорх байдлаар тогтоон зохицуулж байв. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Батлагдсан огноо	ХХДХ-г баталсан Тогтоолын дугаар	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (сараар, төгрөгөөр)
1	1991-07-05	199	560 /2 төгрөг. 87 мөнгө'
2	1991-10-11	294	700
3	1992-12-17	69	1650
4	1993-05-31	94	2145
5	1993-12-15	184	5020
6	1994-09-14	163	6400
7	1995-12-30	243	9600
8	1997-12-31	259	12000
9	2000-07-05	108	24750
10	2000-10-04	155	18000
11	2000-10-04	155	24750
12	2002-12-25	263	30000
13	2004-01-07	4	40000
14	2005-05-25	112	42500

15	2006-02-08	14	53000
16	2007-01-10	12	69000
17	2007-07-10	174	80000
18	2007-09-27	240	90000
19	2007-12-26	350	108000
20	2011-04-05	1	140400
21	2013	7	192000
22	2016	4	240000

Харин ОУ-ын Хөдөлмөрийн Байгууллагын 1970 оны 131-р конвенцэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох зарчмуудыг бэхжүүлсэн. Тухайлбал: Цалингийн доод хэмжээний түвшинг тогтоохдоо аль ч улс улсын хэмжээний цалингийн ерөнхий түвшинг харгалзан тооцсон ажилчид, тэдний гэр бүлийнхний хэрэгцээ, амьжиргааны өртөг, нийгмийн даатгалын тэтгэмж, нийгмийн зарим хэсгийн амьжиргааны түвшингийн харьцаа, эдийн засгийн хөгжлийн шаардлагыг харгалзсан эдийн засгийн хүчин зүйлс, бүтээмжийн түвшин, ажил эрхлэлтийн өндөр түвшинг хангах болон түүнд хүрэхийг эрмэлзэн өөрийн үндэсний бодит нөхцөл байдалд нийцүүлж зохицуулна. ОУ-ын энэ стандартыг харгалзан МУ-д хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зохицуулж ирсэн билээ.

Дээрхээс үзэхэд:

1. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэсэн ойлголт бол Хөдөлмөрийн эрх зүйн харилцааг зохицуулахаар тооцоолж гаргасан хэмжүүрийг ойлголтыг Эрүүгийн эрх зүйн материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэргийн объектив талын үндсэн шинжийн нэг болох хохиролын хэмжээг тодорхойлоход хэрэглэж ирсэн нь амьдралд дээр гарсан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоох, гэмт хэрэг, зөрчлийг ялгах зааг болж буй асуудлыг өөрчлөх шаардлагатай байна.

2. Хор уршиг нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлоос өргөн хүрээтэй ойлголт бөгөөд гэмт хэргийн улмаас учирсан Эрүүгийн хуульд заасан бүх үр дагаврыг хамруулдаг бол хохирол нь хэргийн улмаас бусдын өмчлөх эрх, өмчлөгчийн эрх ашиг сонирхолд

учирсан мөнгөн илэрхийллээр илэрч буй хор уршиг тул хохирол талаас бус гэмт хэргийн хор уршиг ялангуяа нийгэмд хор аюулын хэр хэмжээг харгалзан төрийн ял, шийтгэлийн бодлоготой уялдуулан тогтоож авч үзэх нэн чухал байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монголын улсын Эрүүгийн хууль. 2002.
2. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль. 1999.
3. Монгол Улсын Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль. 2010.
4. Монголын Улсын Иргэний хууль. 2002.
5. Ж.Болдбаатар, З.Төрмандах. Эрүүгийн эрх зүй. УБ., 2008.
6. С.Жанцан. "Монгол улсын Эрүүгийн эрх зүйн онол". УБ., 2009.
7. С.Жанцан. "Монгол улсын Эрүүгийн эрх зүй ерөнхий ба тусгай анги". УБ., 2012.
8. Трудовой кодекс. 2002.
9. Л.Баасан. Монгол Улсын Хөдөлмөрийн эрх зүй. УБ., 2010.
10. Кисилев М.Я. Сравнительное и международное трудовое право. М., 1999
11. Куреннов А.М. Трудовое право России. М., 2004. Стр. 142
12. <http://www.labornet.mn/news/show/id/437>
13. <http://www.ikon.mn/n/pxg>

Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн, Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, хууль зүйн доктор, цагдаагийн хошууч Б.Энхболд



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨРИЙН
ТУХАЙ ХУУЛЬ